



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН
ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“2. “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төслийг Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдулам танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дугаар зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хууль, эрхзүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх (Д. Цолмон)-д;

2. Хотын стандартыг мөрдүүлэхэд оролцогч нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай хэлэлцүүлэг зохион байгуулахыг Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т тус тус үүрэг болгов” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1110200469